

**“ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ,
ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ” НИЙЦЛИЙН АУДИТ**

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баянхонгор аймаг

2018 он

Агуулга	
Аудитын нэр	2
Аудитын код	2
Аудит хийх бүрэн эрх, үндэслэл	2
Аудитын зорилт	2
Аудитын хамрах хүрээ	2
Үндсэн мэдээлэл	3
Эрсдэлийн үнэлгээ	3
Аудитын арга зүй	3
Аудитын үр өгөөж	4
Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Аудитыг гүйцэтгэх хугацаа	4
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	4
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	4
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	5

БАТЛАВ: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



2018.05.09

Баянхонгор

Аудитын нэр

Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал.

Аудитын код

БНА-2018/04-НА

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Монгол улсын ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт

Орон нутгийн өмчийн хөрөнгөнд 2017 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд аудит хийж аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. / Асуудлын шинжилгээ хавсралт №2-д үзүүлэв/ Үүнд :

- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх?
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх?

Аудитын хамрах хүрээ

Аудитыг Баянхонгор аймгийн ОНӨГ болон барилга байгууламжийг ашиглагч төсвийн байгууллагууд, ОНӨААН, ОНӨ-ийг түрээсээр ашиглагч ӨЭМТ-үүдийн 2014-2017 оны санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгийн данс бүртгэл, хөрөнгийн

ашиглалт, судалгаа, мэдээлэл үйл ажиллагааны тайлан холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэнэ.

Үндсэн мэдээлэл

Аймгийн ОНӨГ нь 2017 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 262 байгууллагын 183693,3 сая төгрөгийн барилга байгууламжийн дүнг нэгтгэснийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн байна.

ОНӨГ-ын нэгдсэн бүртгэлд 2014 онд 164503,2 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлтэй байсан бол 2014-2017 онд 19187,1 сая төгрөгөөр нэмэгдэж 183693,3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар дээрхи барилга байгууламжид 62403,5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцож 121289,8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй байна.

Д/Д	ОН	2014.12.31	2015.12.31	2016.12.31	2017.12.31	өөрчилөл т
1	Байгууллагын тоо	223	223	265	262	39
2	Барилга байгууламжийн дүн / сая төг/	164,506.2	172,168.9	174,294.2	183,693.3	19,187.1
3	Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл	49,862.5	53,371.2	57,475.9	62,403.5	12,541.0
4	Үлдэх өртөг	114,643.66	118,797.70	116,818.27	121,289.78	6,646.1

Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, судалгаанд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг "Дунд" гэж үнэлэв. / Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-т үзүүлэв/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журамыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. /Аудитын арга зүйг хавсралт №3-д үзүүлэв/

Аудитын үр өгөөж

Аудитын төлөвлөлтийн шатанд аудитын үр өгөөжийг 70.0 сая төгрөгөөр тооцов. */Аудитын үр өгөөжийг хавсралт №5-д үзүүлэв/*

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг гүйцэтгэх хугацаа

Аудитыг 5-р сарын 14-нөөс 06 дугаар сарын 15-ны хооронд хийж, үе шатны хяналтаар оруулан хянуулж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Тэргүүлэх аудиторoor баталгаажуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд болон холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. *(Аудитын хөтөлбөрийг хавсралт №4-д үзүүлэв)*

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитын явцыг хянан удирдах ажилтан: Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д. Цэцэгмаа үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

Аудит хийх аудитор: Ахлах аудитор А.Цээням, аудитор Ж.Өсөхбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмжтэй байхаас гадна холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар бичигдэнэ.

Аудитын тайлангийн төслийг дарга, тэргүүлэх аудиторын зөвшөөрснөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, тайлангийн

эцсийн хувилбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: 2 хүн *25 өдөр=50 хүн/өдөр.

б. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал 2200,0 мянган төгрөг, бичиг хэрэг 10,0 мянган төгрөг, шатахууны зардал 150,0 мянган төгрөг нийт 2360,0 мянган төгрөг

в. Техник хэрэгсэл: зөөврийн компьютер, принтер, скайнер, диктафон бусад техник хэрэгсэл

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЯНАЖ ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЦЭЦЭГМАА

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

 А.ЦЭЭНЯМ


 Ж.ӨСӨХБАЯР

2018 оны 05 дугаар сарын 09-ны өдөр

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

№	Эрсдэл	Магадлал /Их, дунд, бага/	Үр дагавар /Их, дунд, бага/	Үнэлгээ /Их, дунд, бага/
1	Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хувийн хэрэг хөтөлж баяжилтийг хийгээгүй, паспортжуулаагүй байх	Дунд	Их	Дунд
2	Орон нутгийн өмчийн барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаагүй байх	Их	Их	Их
3	Орон нутгийн өмчид 2014-2017 онд шинээр нэмэгдсэн барилга байгууламжийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй байх	Дунд	Их	Дунд
4	Хөрөнгийг түрээслэхдээ түрээсийн гэрээ байгуулаагүй, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөөгүй байх	Дунд	Их	Дунд
5	Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд нь төвлөрүүлээгүй байх	Дунд	Дунд	Дунд
6	Эд хөрөнгө бэлтгэх, худалдах, шилжүүлэх, актлах, бүртгэхдээ хууль тогтоомжийг мөрдөөгүй байх.	Дунд	Их	Дунд
7	Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллого хийгээгүй байх	Дунд	Их	Дунд
8	Байгууллагын даргын тушаалаар өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулаагүй байх,	Дунд	Их	Дунд
9	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тайланд тусгагдсан барилга байгууламжийг орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүрэн бүртгээгүй байх.	Дунд	Дунд	Дунд
10	Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй.	Дунд	Их	Дунд
Ерөнхий үнэлгээ		Дунд	Их	Дунд

Жич: Эрсдэлийн үнэлгээний үндсэн загвар



АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнтэй хэрэгжиж байна уу?

1.Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх?

2.Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх?

1.1.Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хувийн хэрэг хөтөлж, паспортжуулсан уу?

1.2 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаж бусдад түрээслэхдээ холбогдох хууль, тогтоомжийг мөрдсөн үү?

1.3 Эд хөрөнгө бэлтгэх, худалдах, шилжүүлэх, актлах, бүртгэх ажил холбогдох хууль тогтоомжтой нийцсэн үү?

2.1 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж үр дүнг тооцож ажилласан эсэх?

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тайланд тусгагдсан барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүрэн бүртгэсэн эсэх?

2.3 Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хэрэгжүүлсэн үү.

АРГА ЗҮЙ

Аудитын нэр: Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал

Аудитын код: БНА-2018/04-НА

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)		ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛ ИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
Үндсэн зорилт: Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнтэй хэрэгжиж байна уу?						
1.Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх?						
1.1.ОНӨ-ийн барилга байгууламжийг хувийн хэрэг хөтөлж, паспортжуулсан уу?	Тухайн барилга байгууламжийн хувийг хөтөлж баяжуулж байгаа юу?	Барилгын тухай хуулийн 46.1.2.энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтөлж; 35.1.4. тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;	Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл, судалгаа ОНӨГ-ын Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд тайлагнасан тайлан	-Байгууллагын санхүүгийн тайлан Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, баримтууд	Холбогдох баримт материалтай танилцах	
	Тухайн барилга байгууламжийг паспортжуулсан уу?					
1.2 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаж бусдад түрээслэхдээ холбогдох хууль, тогтоомжийг мөрдсөн үү?	Тухайн барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаж байгаа юу?	-Төсвийн тухай хууль -ТБОНӨТХуулийн 26-т " Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана, -27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно. -Аймгийн ИТХТ-ийн 2009.01.27-ны өдрийн 19 тоот тогтоолоор батлагдсан " орон нутгийн барилга байгууламж болон үндсэн хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх журам" -2014-2017 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл	ОНӨГ-ын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан Түрээсийн гэрээг дүгнэсэн ажлын тайлан 2014-2017 онуудад Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-д хийсэн гүйцэтгэл болон нийцлийн аудитын тайлан Байгууллагын албан тоот	Статистик мэдээ, баримтууд Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын тайлагнасан тайлан, мэдээ Аймгийн засаг даргын тамгын газрын, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн холбогдох төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан	Асуулга авах Ярилцлага хийх Судалгаа хийх Бодит нөхцөл байдлыг үнэлэх, Зарим сумдад очиж барилга байгууламжийн холбогдох бичиг баримттай танилцах	Мэдээллийг харьцуулалтын болон баримт бичгийн шинжилгээн ий аргаар боловсруулах Санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах
	Орон нутгийн өмчид 2014-2017 онд шинээр нэмэгдсэн барилга байгууламжийг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эсэх?					
	Тухайн барилга байгууламжаас бусдад ашиглуулж түрээслүүлсэн эсэх?					
	Барилга байгууламжийг түрээслүүлэхдээ түрээсийн гэрээ байгуулсан эсэх?					
	Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан нөхцлөөр төвлөрүүлж байгаа юу?					
Ашиглалтай холбоотой урсгал зардлыг төсөвт бүрэн суулгаж чадаж байгаа эсэх.						

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)		ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛ ИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
1.3 Эд хөрөнгө бэлтгэх, худалдах, шилжүүлэх, актлах, бүртгэх ажил холбогдох хууль тогтоомжтой нийцсэн үү?	2014-2017 онд Шинээр барилга бүртгэлд бүрэн тсгасан уу,	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ" ТБОНӨТХ-ийн 24 "Төрийн өмчийн эд хөрөнгийг олж авах" 24.2 "...батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах..." 31.1-т "... ашиглах хугацаа нь дууссан эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон... эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.1-т худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх; -29.1-т "...хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно" -Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлага худалдах, шилжүүлэх, актлах журам"; НББОУС 16 Үндсэн хөрөнгө, 16.7-15 Хүлээн зөвшөөрөлт, 16.67-71 Данснаас хасалт	-Аймгийн ИТХ-ын шийдвэр, тогтоолууд Засаг даргын захирамж Байгууллагын дотоод хяналтын тайлан Санхүүгийн хяналт аудитын албаны тайлан, мэдээ -Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр	-Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын тайлагнасан тайлан, мэдээ -СХАА, Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэний дүгнэлт тайлан -Холбоотой талуудын тайлбар, -Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, биелэлт -Хөндлөнгийн хяналтын тайлан -Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн тайлан, судалгаа, тооцоо		
2. Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх?						
2.1 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж үр дүнг тооцож ажилласан эсэх?	Барилга байгууламжийн тооллогын тооллогыг хуульд заасан хугацаанд явуулсан эсэх?	ТБОНӨ-ийн тухай хуулийн 70.1-т 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/	-Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, -Удирдлагын тушаал шийдвэрүүд -Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, баримт, хурлын тэмдэглэл	Холбогдох баримт материалтай танилцах	Мэдээллийг харьцуулалтын болон баримт бичгийн шинжилгээн ий аргаар боловсруулах
	Байгууллага дээр өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулсан эсэх?	ТБОНӨТХ-ийн 31.4 "...өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна.				
	Тооллогын дүнг хэлэлцэж үр дүнг тооцсон эсэх?	ТБОНӨТХ-ийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана"				

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)		ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛ ИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
2.2 Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тайланд тусгагдсан барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүрэн бүртгэсэн эсэх?	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжийг Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүрэн бүртгэсэн эсэх? Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн хөрөнгүүдийг "Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем"-д бүрэн оруулсан эсэх?	-ТБОНӨТХ-ийн 78.2.4-т аймгийн Засаг дарга нь " орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах; -"Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем"	-Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн нэр төрлийг ОНӨ-ийн тайлангийн дүнтэй тулган шалгаж тайлбар авах -Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл, судалгаа -ОНӨГ-ын Төрийн өмчийн нэгдсэн бүртгэлд тайлагнасан тайлан	Статистик мэдээ, баримтууд	Лавлагаа асуулга авах	Санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах
2.3 Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг хэрэгжүүлсэн үү.	ОНӨГ-нь 2014-2017 онд орон нутгийн өмчийн барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт хийсэн үү, 2014-2017 онуудад орон нутгийн өмчийн барилга байгууламжийн нэгдсэн бүртгэл хөтлөх, тооллого явуулах ажлыг зохион байгуулсан эсэх?	ТБОНӨ-ийн тухай хуулийн 77.1-т Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй: 77.2. 1-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах; 77.2. 2-т " иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх"	ОНӨГ-ын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ Байгууллагын дотоод хяналтын тайлан -Аймгийн ИТХ-ын шийдвэр, тогтоолууд -Аймгийн Засаг даргын захирамжууд	Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын тайлагнасан тайлан, мэдээ Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн тайлан, судалгаа, тооцоо	Судалгаа хийж бодит нөхцөл байдлыг үнэлэх	